



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/180

Булган сум

“Алтан төлийн эзэд”-ээр шалгарсан малчдад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио телевизийн нэрэмжит “Алтан төлийн эзэд”-ээр шалгарсан малчдад хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 3,320,200 (гурван сая гурван зуун хорин мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024. оны
03 дугаар сарын 01-ны өдрийн А. /130 дугаар
захирамжийн хавсралт

АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	2	3	4	5
1	Талархал	13	87,400	1,136,200
2	Гарын бэлэг	13	168,000	2,184,000
	Нийт			3,320,200